



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 2 дугаар улирлын тайлан



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV
байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbf@frc.mn

Агуулга

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ	3
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	5
Батлан даалтын хэмжээ	5
Батлан даалтын дүн, байршил	5
Батлан даалтын эх үүсвэр	7
Батлан даалт, салбараар	8
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	9
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	9
Батлан даалтын ангилал.....	9
ДҮГНЭЛТ, САНАЛ	12

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Батлан даалт гаргаж буй эх үүсвэр /сая төгрөг/	7
Хүснэгт 2: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	9

Зургийн жагсаалт

Зураг 1: Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	3
Зураг 2: Нийт хөрөнгийн бүтэц, хувиар.....	4
Зураг 3: Батлан даалтын хэмжээ	5
Зураг 4: Зээлдэгчдийн тоо, байршлаар.....	6
Зураг 5: Батлан даалтын дүн, байршлаар.....	6
Зураг 6: Батлан даалтын тоо, аймгаар.....	6
Зураг 7: Батлан даалтын хэмжээ, аймгаар.....	7
Зураг 8: Нийт гаргасан батлан даалт, эдийн засгийн салбараар.....	8
Зураг 9: Зээлийн ангилал.....	10
Зураг 10: Батлан даалтын ангилал	10
Зураг 11: Чанаргүй батлан даалтын хувь, хэмжээ /тэрбум төгрөг/	11

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн Батлан Даалтын Сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулан ажилладаг. Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу санхүүгийн тайлан, батлан даалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг авч, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлж ажиллаж байна.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах.” гэж заасан. Зээлийн батлан даалтын сан нь Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 2023 оноос эхлэн 21 аймаг болон Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд банк санхүүгийн байгууллагаас орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл авахыг хүссэн, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дутагдалтай иргэнд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргаж эхэлсэн.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 257.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт хөрөнгийн 80.0 хувь буюу 206.0 тэрбум төгрөг нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө байна.

Сангийн нийт хөрөнгийн 68.3 хувийг буюу 175.9 тэрбум төгрөг нь өр төлбөр, 31.7 хувийг буюу 81.7 тэрбум төгрөгийг сангийн цэвэр хөрөнгө бүрдүүлж байна.

Зураг 1: Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/



Зураг 2: Нийт хөрөнгийн бүтэц, хувиар



Нийт өр төлбөрийн 96.6 хувь буюу 169.9 тэрбум төгрөг нь урт хугацаат өр төлбөр эзэлж байгаа бөгөөд 3.4 хувь буюу 6.0 тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн 74.3 хувь буюу 126.3 тэрбум төгрөг нь урт

хугацаат зээл, 2.1 хувь буюу 3.5 тэрбум төгрөг нь урт хугацаат зээлийн хүүний өглөг, 23.6 хувь буюу 40.1 тэрбум төгрөг нь бусад урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Сангийн цэвэр хөрөнгө 81.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар буюу 7.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт орлого 5.6 тэрбум төгрөг ба үүнээс 1.3 тэрбум төгрөгийн зардал, 4.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Нийт орлогын 89.6 хувь буюу 5.1 тэрбум төгрөг нь хадгаламжийн хүүгийн орлого, 10.4 хувь буюу 585.7 сая төгрөг нь батлан даалтын шимтгэлийн орлого бүрдүүлж байна.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Батлан даалтын хэмжээ

2023 оны 2 дугаар улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 10 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй бөгөөд үүнээс 7 банк, 1 банк бус санхүүгийн байгууллагаар батлан даалт гарч байна. Сангийн батлан даалтын үлдэгдэл 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 85.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өссөн байна. Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл нь 166.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар батлан даалтын 132 хүсэлт шинээр ирснээс нийт

14.1 тэрбум төгрөгийн 97 батлан даалтыг шинээр гаргахаар шийдвэрлэсэн байна. Батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн хүсэлтүүдийн 43 нь ипотекийн зээлд гаргасан батлан даалт байгаа бөгөөд нийт 3.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээлд 626.3 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 623 зээлдэгчид 85.5 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байгаагаас 67 зээлдэгчийн 9.4 тэрбум төгрөгийн батлан даалт буюу 10.9 хувь нь чанаргүй байна.

Зураг 3: Батлан даалтын хэмжээ




Батлан даалтын дүн, байршил

Зээлийн батлан даалтын сан 2013 оноос эхлэн нийт 1217 зээлдэгчид батлан даалт гаргасан бөгөөд нийт зээлдэгчдийн 67.1 хувь нь Улаанбаатар хотод, 32.9 хувь нь орон нутгийн зээлдэгчид байна.


Нийт батлан даалтын хэмжээг мөнгөн дүнгээр нь авч үзвэл 77.5 хувь нь Улаанбаатар хотод, 22.5 хувь нь орон нутгийн зээлдэгчдэд батлан даалт гаргасан байна. Энэхүү статистикаас орон нутагт зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлж, боломжит зохистой харьцаа хүртэл батлан даалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь

харагдаж байна.

Зураг 4: Зээлдэгчдийн тоо, байршлаар



Зураг 5: Батлан даалтын дүн, байршлаар




Батлан даалт гаргасан зээлдэгчдийн тоог аймгаар задлан харвал Дархан-Уул аймагт 53, Орхон аймагт 42, Өвөрхангай аймагт 40, Сэлэнгэ аймагт 40, Дорнод аймагт 30, Ховд аймагт 29, бусад аймгуудад дараах байдлаар батлан даалт гаргасан байна.

Зураг 6: Батлан даалтын тоо, аймгаар



Батлан даалтын хэмжээг аймгаар задлан харвал Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай, Орхон, Өмнөговь аймгуудад хамгийн их хэмжээтэй байна.

Зураг 7: Батлан даалтын хэмжээ, аймгаар



Батлан даалтын эх үүсвэр

Зээлийн батлан даалтын сан нь 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 17 төсөл болон банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлд батлан даалт гаргасан байна. Үүнд:

Хүснэгт 1: Батлан даалт гаргаж буй эх үүсвэр /сая төгрөг/

№	Төслийн нэр	Батлан даалтын хэмжээ /сая төгрөг/	Зээлдэгчдийн тоо
1	Ажлын байрыг дэмжих зээл	28,456.4	208
2	Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн бизнесийн үйлчилгээг дэмжих сан	49.2	4
3	Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл	103,145.7	458
4	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөл	21.0	2
5	АХБ-ны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл	300.0	1
6	Барилга, хот байгуулалтын яамны төсөл	250.0	1
7	Жайка	9,880.6	57
8	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсөл	7,864.8	94
9	Ипотек	626.3	43
10	Монгол 888 төсөл	1,329.0	10

11	Монсеффийн төсөл	420.0	1
12	Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	412.2	9
13	Органик Монгол хөтөлбөр	3.0	1
14	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах төсөл /ХХААХҮЯ/	1,626.2	5
15	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны төсөл /ХХААХҮЯ/	6,933.4	67
16	Хөгжлийн банк	2,499.9	1
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	161.0	54
18	Банк	16,212.5	195
19	Банк бус санхүүгийн байгууллага	97.0	3

Батлан даалт, салбараар

Нийт батлан даалт гаргасан салбараар нь ангилж үзвэл боловсруулах үйлдвэр 34.9 хувь, бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа 31.4 хувь, хөдөө аж ахуй ан агнуур ойн аж ахуй 6.9 хувь, эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар 6.2 хувь, аялал жуулчлал зочид буудал зоогийн газар 6.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 8: Нийт гаргасан батлан даалт, эдийн засгийн салбараар

Батлан даалтын хувь, салбараар



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг баталсан бөгөөд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар заасан.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 2: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Тайлангаар	Хангасан эсэх
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Өөрийн хөрөнгийн байвал зохих доод хэмжээ	5'000'000'000	81,698,125,763.26	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	31.72%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	85,514,622,036.07	Хангасан
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	117.14%	Хангасан
АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60.00%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	4.22%	Хангасан
Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.00%	Хангасан
Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.00%	Хангасан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1.69%	Хангасан
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.21%	Хангасан
НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	2,134,740,260.64	2,200,000,000.00	Хангасан
ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	10.99%	Хангасан

Зээлийн батлан даалтын сан нь “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д заасан 12 зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан байна.

Батлан даалтын ангилал

Зээлийн батлан даалтын сан нь байгуулагдсанаасаа хойш нийт 1217 зээлдэгчдийн 366.8 тэрбум төгрөгийн зээлд 181.8 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сан нь 623 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн 166.8 тэрбум төгрөгийн зээлд 85.5 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байна.

Зураг 9: Зээлийн ангилал



Зураг 10: Батлан даалтын ангилал



Нийт батлан даалт гаргасан зээлийн багцын 83.2 хувь нь хэвийн зээл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өссөн, 14.3 хувь нь чанаргүй зээл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.06 хувиар өссөн, анхаарал хандуулах зээл 2.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан байна.

Нийт батлан даалтын багцад эзлэх хэвийн батлан даалтын хувь 86.0 хувь буюу 73.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн бол анхаарал хандуулах батлан даалтын хувь 3.0 хувь буюу 2.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн, чанаргүй батлан даалтын хувь 11.0 хувь буюу 9.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурсан байна.

Чанаргүй батлан даалтын хувь 2020 онд өндөр байгаа нь коронавируст цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа тасалдаж, зээлийн эргэн төлөлт удааширсантай холбоотой юм.

Зураг 11: Чанаргүй батлан даалтын хувь, хэмжээ /тэрбум төгрөг/



Чанаргүй батлан даалтын ангилалд орсон 67 зээлдэгчдээс 56 зээлдэгчийн 6.2 тэрбум төгрөгийн батлан даалтад үүргийн гүйцэтгэл хангуулж 0.6 тэрбум төгрөгийн авлага төлөгдөж, 5.6 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа хэвийн, зохистой харьцаануудыг хангаж ажиллаж байгаа бөгөөд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх хэмжээнд батлан даалт гаргах боломжтой тул боломжит зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд тохируулан гаргах батлан даалтын хэмжээг нэмэгдүүлбэл зээлдэгчдэд батлан даалтын хүртээмж сайжирна.

Нийт гаргасан батлан даалтын дийлэнх хувийг Улаанбаатар хотын зээлдэгчид эзэлж байгаа бөгөөд орон нутгийн зээлдэгчид батлан даалт гаргуулахад бодлогоор дэмжиж, мэдээлэл өгч ажиллах шаардлагатай байна.

2023 оноос эхлэн Улаанбаатар хотын алслагдсан 3 дүүрэг, орон нутагт ипотекийн зээлээр орон сууц худалдан авч буй иргэд зээлийн батлан даалт гаргуулах боломж бүрдсэн бөгөөд 2 дугаар улирлын байдлаар 43 иргэний ипотекийн зээлд батлан даалт гаргасан байна.

Батлан даалт гаргаж буй эдийн засгийн салбаруудаас боловсруулах үйлдвэр 34.9 хувь, бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа 31.4 хувийг тус тус эзэлж байгаа нь нийт батлан даалтын 66.3 хувийг бүрдүүлж байна. Бусад салбаруудын нийт батлан даалтад эзлэх хувь дээрх 2 салбартай харьцуулахад маш бага байгаа бөгөөд эдийн засгийн салбаруудад батлан даалтын хүртээмж нь жигд бус байгааг харуулж байна. Иймд нийт батлан даалтад эзлэх салбаруудын хувийг жигд болгож, салбаруудад олгож буй батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Батлан даалтын багцын ангилалд эзлэх хэвийн батлан даалт 85.9 хувь, анхаарал хандуулах батлан даалт 3.0 хувь, чанаргүй батлан даалт 10.9 хувь байгаа бөгөөд батлан даалтын чанар болон үүргийн гүйцэтгэлийг сайжруулахад анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 10 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага харилцаж байгаа бөгөөд цаашид банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодыг Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, зээлдэгчид батлан даалт гаргуулах боломж бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны харилцагч, барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчид батлан даалт гаргах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР